



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/02

Төгөл

Мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг 01 дугаар хавсралтаар, Мөрөн сумын модны хэрэгцээг хангах ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийг 02 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Мод бэлтгэлтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байгууллага, албан тушаалтанд ДААЛГАХ нь:

-Малчин иргэдийн хэрэгцээнд хэрэглээний модны 40-өөс доошгүй хувийг зарцуулахаар хуваарилалт хийж, мод бэлтгэлийн ажил явуулсан ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэл, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг тооцож ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (М.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

-Ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт (гэрэлжүүлэх, тохируулахаас бусад) явуулсан ойн мэргэжлийн байгууллагын бэлтгэсэн 100 м3 хэрэглээний мод тутамд 2 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийлгэх, ойжуулалтын ажлын 50 хувийг сум дундын ойжуулалтын арга хэмжээнд татан гүйцэтгүүлэх ажлыг Баяншишгэд сум дундын ойн ангийн даргыг түр орлон гүйцэтгэгч (М.Бямбацогт)-д үүрэг болгосугай.

-Мод бэлтгэлийн ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж, байгууллагуудын ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч өөрийн хөрөнгөөр хийгдэх ойжуулалтын ажлыг хавар 5 сард хийж намар 9 дүгээр сард ургалтын үр дүнг тооцуулж хүлээлгэж өгөөгүй байгууллагуудыг (байгаль орчин, аялал жуучлалын газрын тодорхойлолтоор) мод бэлтгэх хуваарьт оруулахгүй байх.

-Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ойгоос мод бэлтгэсэн мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээг сар бүр дүгнэж, мод модон материалын нийлүүлэлтийг цахимаар сурталчилж, мэдээллээр хангаж ажиллахыг Баяншишгэд сум дундын ойн ангийн даргыг түр орлон гүйцэтгэгч (М.Бямбацогт)-т үүрэг болгосугай.

-Мод бэлтгэлийн дээд хязгаар, мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /Г.Батчимэг/, бүсийн экологийн цагдаад үүрэг болгосугай.

3.Мөрөн сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын түлээний мод, хэрэглээний модны хэрэгцээг Мөрөн сумын Засаг даргатай гэрээ байгуулж нийлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (М.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.БАТБАЯР

0072284 6715114294

Улаан-Уул сумын 2024 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн 1/02 дугаар
Захирамжийн Нэгдүгээр хавсралт

| № | Улаан -Уул суманд 2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ | | | | | | | | | | | | | | Нийт дүн/м куб/ | | |
|----|---|----------------------------|------------|-------------|-------------------------------|------------|-------------|----------------------------|--------------|--------------|--------------------------------|--------------|-----------------|-----------|-----------------|--------------|--------------|
| | ААНБ, ОН, багийн нэр | Арчилгааны огтлолт /м куб/ | | | Цэвэрлэгээний огтлолт /м куб/ | | | Цэвэрлэгээний ажил /м куб/ | | | Уламжлалт бүтээгдэхүүн /м куб/ | | | | Хэрэглээ | Түлээ | Дүн |
| | | Хэрэглээ | Түлээ | Дүн | Хэрэглээ | Түлээ | Дүн | Хэрэглээ | Түлээ | Дүн | Шинэс хэрэглээ | Хуш хэрэглээ | Гацуур хэрэглээ | Дүн | | | |
| 1 | Босгот хангай ХХК | 385 | 75 | 460 | 133 | 330 | 463 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 518 | 405 | 1250 |
| 2 | Өргөн хөг ХХК | 385 | 75 | 460 | 133 | 330 | 463 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 518 | 405 | 923 |
| 3 | Нэмэл хангай ХХК | 150 | 50 | 200 | 133 | 330 | 463 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 283 | 380 | 663 |
| 4 | Ушигдай /Нөхөрлөл/ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 20 | 50 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 20 | 50 | 70 |
| 5 | Шивлэг 1-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 1630 | 1690 | 10 | 14 | 0 | 24 | 84 | 1630 | 1714 |
| 6 | Тоом 2-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 1630 | 1690 | 10 | 0 | 0 | 10 | 60 | 1630 | 1690 |
| 7 | Мунгараг 3-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 1630 | 1690 | 10 | 0 | 0 | 10 | 70 | 1630 | 1700 |
| 8 | Соёо 4-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 1630 | 1690 | 10 | 14 | 0 | 24 | 74 | 1630 | 1704 |
| 9 | Төгөл 5-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 3500 | 3560 | 10 | 0 | 0 | 10 | 70 | 3500 | 3570 |
| 10 | Гун 6-р баг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 60 | 1630 | 1690 | 10 | 0 | 0 | 10 | 70 | 1630 | 1700 |
| | Дүн | 920 | 200 | 1120 | 399 | 990 | 1389 | 380 | 11700 | 12010 | 50 | 28 | 0 | 78 | 1767 | 12890 | 14984 |